


Дэлгэрэнгүй мэдээлэл авах:
Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан
түгээх сүлжээ ТӨХК
Захиргаа хүний нөөцийн хэлтэс
Захиргаа хүний нөөцийн хэлтсийн
дарга Я.Отгонзул
И-мэйл: baganuur@bnedo.mn
Утас: 70210167



СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ

2024-2030



КОМПАНИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, БОДЛОГЫН ЧИГЛЭЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2024-2030 ОН

Компанийн хөгжлийн бодлогын зорилго, зорилт, уялдаа

Компанийн хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг дараах уялдаатайгаар тодорхойлж байна.

2024-2030 онд хэрэгжүүлэх ТҮГЭЭХ үйл ажиллагааны бодлогын зорилго нь шугам, тоноглолын шинэчлэлийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, түгээх сүлжээний найдвартай ажиллагааг сайжруулахад оршино.

Зорилт 1: Түгээх сүлжээний техникийн бодлогыг боловсруулан, сүлжээнд холбогдох шугам тоноглолд тавигдах шаардлага, стандартыг иж бүрэн тодорхойлж, мөрдүүлэх.

Зорилт 2: Түгээх сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний стандартын мөрдөлт, шугам тоноглолын шинэчлэлийн үр дүнг сайжруулж, найдвартай ажиллагааны үзүүлэлтийг дээшлүүлэх.

Зорилт 3: Түгээх сүлжээний шинэ холболтын журам, зохицуулалтыг шинэчлэн, түгээх үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

2024-2030 онд хэрэгжүүлэх ХАНГАХ үйл ажиллагааны бодлогын зорилго нь өсөн нэмэгдэж буй хэрэглэгчдэд ухаалаг технологид суурилсан шуурхай, хүртээмжтэй, иж бүрэн үйлчилгээг үзүүлэхэд оршино.

Зорилт 1: Үйлчилгээний дэг жаягийг шинэчлэн мөрдүүлж хэрэглэгчдэд чанартай, шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх

Зорилт 2: Ухаалаг технологид суурилсан үйлчилгээний хүртээмжийг сайжруулж эрчим хүч хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх

Зорилт 3: Мэдээллийн технологид суурилсан үйлчилгээний шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлэх

2024-2030 онд хэрэгжүүлэх ТЕХНОЛОГИЙН шинэчлэлийн бодлогын зорилго нь хэрэглэгчийн үйлчилгээ болон дотоод үйл ажиллагааг цогц менежментийн системд нэгтгэн удирдаж, үр ашигтай, найдвартай сүлжээ бүтээх замаар компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Зорилт 1: Өгөгдөл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.

Зорилт 2: Ухаалаг сүлжээний дэд системүүдийг холбож, мэдээллийн технологид суурилсан сүлжээний удирдлагыг бүрэн нэвтрүүлнэ.

Зорилт 3: Хөрөнгийн менежментийн цогц систем нэвтрүүлнэ.

2024-2030 онд баримтлах ХҮНИЙ НӨӨЦИЙН хөгжлийн бодлого нь ур чадвартай, бүтээмжтэй хүний нөөцийг тогтвортой бүрдүүлэхэд оршино.

Зорилт 1: Түгээх, хангах үйл ажиллагааны шинэчлэлийн зорилтод нийцүүлэн тасралтгүй хөгжүүлэн хүний нөөцийг чадавхжуулна.

Зорилт 2: Гүйцэтгэлд суурилсан цалин хөлс, урамшууллын системийг нэвтрүүлэх замаар хүний нөөцийг оновчтой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

Зорилт 3: Хүний нөөцийн удирдлагын чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулна.

2024-2030 онд баримтлах ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН зорилт:

Зорилт 1: ISO 45001 стандартыг нэвтрүүлнэ.

СТРАТЕГИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Ухаалаг сүлжээ гэдэг нь цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангахын тулд цахилгааныг бүх төрлийн эх үүсвэрээс эцсийн хэрэглэгчид хүргэх тээвэрлэлтийг хянаж, удирдахад дижитал болон бусад дэвшилтэт технологийг ашигладаг цахилгаан эрчим хүчний сүлжээ юм.

2024-2030 онд хэрэгжүүлэх стратегийн баримт бичигт “Ухаалаг сүлжээ нь бүх төрлийн цахилгаан үүсгүүр, сүлжээний операторууд, эцсийн хэрэглэгчид болон цахилгааны зах зээлийн оролцогчдын хэрэгцээ, чадамжийг зохицуулж, системийн бүх хэсгийг аль болох үр ашигтайгаар ажиллуулан, зардлыг багасгах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахын зэрэгцээ системийн найдвартай байдал, уян хатан байдал, тогтвортой байдлыг хамгийн ихээр хангахыг зорьдог сүлжээ юм.” гэсэн тодорхойлолтыг мөрдөнө.

2024-2030 онд ухаалаг сүлжээний техник, технологийн нөхцөлийг ханган, ухаалаг сүлжээний системийг дараах үе шаттайгаар бүрдүүлнэ. Үүнд:

1. Тоноглолыг шинэчлэн, эрх зүйн орчныг бүрдүүлж, кибер аюулгүй байдлын уялдаа холбоо, хэрэгжилтийг хангах цогц үйл ажиллагаа,
2. Хөрөнгийн менежментийн системийн нэвтрүүлэлт,
3. Өгөгдлийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт, ашиглалт,
 - Хөрөнгийн өгөгдлийн (газар зүйн мэдээллийн систем) сан
 - Хэрэглэгчийн мэдээллийн сан
 - Тасралт, саатлын мэдээллийн сан
 - Бусад өгөгдлийн сан
4. Ухаалаг тоолуурын нэгдсэн системийг нэвтрүүлэх,
5. Төлөвлөлт болон даацын системийг хөгжүүлэх,
6. Тасралт саатлын системийг сайжруулах,
7. Ухаалаг сүлжээний элементүүдийг нэвтрүүлж, хэрэглэгчдийг дэмжсэн идэвхтэй түгээх сүлжээг бий болгох.

Стратегийн зорилгын хүрээнд компанийн 2024-2030 онд хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд нь технологийн шинэчлэл, хүний нөөцийн хөгжлийн асуудал байна.

БЗӨБЦТС ТӨХК-ийн үндсэн чиг үүргийг тодорхойлох үйл ажиллагааны хоёр чиглэл болох түгээх болон хангах үйлчилгээнд зориулсан бодлогын зорилго, зорилтууд, 2024-2030 онд хүрэхээр төлөвлөж буй үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах хэсэгт тусгалаа.

Түгээх үйл ажиллагааны бодлогын зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилго: 2024-2030 онд хэрэгжүүлэх ТҮГЭЭХ үйл ажиллагааны бодлогын зорилго нь шугам, тоноглолын шинэчлэлийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, түгээх сүлжээний найдвартай ажиллагааг сайжруулахад оршино.

Шалгуур үзүүлэлт: Түгээх сүлжээний найдвартай байдлын үзүүлэлт сайди, сайпи сайжирсан байна.

Зорилт	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	Санхүүжүүлэх эх үүсвэр	Хариуцах нэгж
Зорилт 1. Түгээх сүлжээний техникийн бодлогыг боловсруулан, сүлжээнд холбогдох шугам тоноглолд тавигдах шаардлага, стандартыг иж бүрэн тодорхойлж, мөрдүүлэх.	Компанийн хөгжлийн бодлого, ухаалаг сүлжээний нөхцөл, шаардлагад нийцүүлэн техникийн дүрэм, журмыг шинэчлэн сайжруулан холбогдох эрх бүхий байгууллагатай зөвшилцөж, зайлшгүй мөрдөх эрх зүйн орчин бүрдүүлэх	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	- Түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, - Захиргаа хүний нөөцийн хэлтэс - Санхүү эдийн засгийн хэлтэс
	Түгээх сүлжээг төлөвлөх, шинэчлэх, өргөтгөх, ашиглалт, засвар үйлчилгээний мэдээлэл, баримт бичгийн нэгдсэн санг бүрдүүлэх, шинэчлэх		
	Шугам тоноглолын стандарт, шаардлагыг сүлжээний технологийн шинэчлэлд нийцүүлэн шинэчилж батлан мөрдүүлэх		
	Шугам сүлжээний газрын асуудал, хамгаалалтын зурваст холбогдох эрх зүйн зохицуулалтыг шийдвэрлэж эрх бүхий байгууллагуудаар баталгаажуулж мөрдөх		
	Хэрэглэгчийн нар, салхины жижиг оврын эх үүсвэрийг нэгдсэн сүлжээнд холбох нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд мөрдөх стандартыг боловсруулж, мөрдүүлэх		
Зорилт 2: Түгээх сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний стандартын мөрдөлт, шугам тоноглолын шинэчлэлийн үр дүнг сайжруулж, найдвартай ажиллагааны үзүүлэлтийг дээшлүүлэх.	Сүлжээний хөгжлийг шинэчлэн түүнтэй уялдуулан шугам тоноглолын шинэчлэлийг үе шаттайгаар хийх	Тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын зардлын санхүүжилт	- Түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, - Захиргаа хүний нөөцийн хэлтэс - Санхүү эдийн засгийн хэлтэс - Худалдан авах ажиллагаа, хангамжийн хэлтэс
	Ашиглалт, засвар үйлчилгээний техникийн шаардлагын тодорхойлолтыг шинэчлэн сайжруулах, шинээр боловсруулах	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	
	Гэмтэл устгах хугацааг бууруулахад шаардлагатай тоноглолын хэрэгцээг тодорхойлж шинэчлэх	Тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын зардлын санхүүжилт	
	Гэмтлийн тоо, хугацааг бууруулах зорилгын хүрээнд ашиглалт, засвар үйлчилгээний албуудыг мэргэшүүлэн зохион байгуулалтыг өөрчлөх	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	

Зорилт 3: Түгээх сүлжээний шинэ холболтын журам, зохицуулалтыг шинэчлэн, түгээх үйл ажиллагааны чанар, хүргээмжийг нэмэгдүүлэх.	Түгээх сүлжээнд шинээр холбох холболтын бодлогын дэг жаяг, мөрдөх журмыг шинэчлэн мөрдүүлэх	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	- Түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, - Захиргаа хүний нөөцийн хэлтэс - Санхүү эдийн засгийн хэлтэс - Худалдан авах ажиллагаа, хангамжийн хэлтэс
	Түгээх сүлжээнд холбох шинэ шугам, тоноглолд тавих шаардлагыг технологийг хөгжлийн бодлоготой уялдуулан шинэчилж Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслүүдэд мөрдүүлэх эрх зүйн орчныг тодорхой болгох, мөрдүүлэх	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	
	Сүлжээнд шинээр холбогдох гаднын эзэмшлийн шугам тоноглол, төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжих ажлын шугам тоноглолын угсралтын явцад стандарт, шаардлагын биелэлтийг хянах тогтолцоог бүрдүүлэх	Тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын зардлын санхүүжилт	
	Шинэ холболтын болон түгээхийн бусад үйлчилгээг хүргэх үйлчилгээний танхим, нэг цэгийн үйлчилгээ, дуудлагын төв ажиллуулж, хэрэглээний аппликейшн хөгжүүлж нэвтрүүлэх	Тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын зардлын санхүүжилт	

Хангах үйл ажиллагааны бодлогын зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилго: 2024-2030 онд хэрэгжүүлэх ХАНГАХ үйл ажиллагааны бодлогын зорилго нь өсөн нэмэгдэж буй хэрэглэгчдэд ухаалаг технологид суурилсан шуурхай, хүртээмжтэй, иж бүрэн үйлчилгээг үзүүлэхэд оршино.

Шалгуур үзүүлэлт: Хэрэглэгчдийн тоо, борлуулсан цахилгаан эрчим хүчний хэмжээ өссөн байна. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин нэмэгдсэн байна.

Зорилт	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	Санхүүжүүлэх эх үүсвэр	Хариуцах нэгж
Зорилт 1: Үйлчилгээний дэг жаягийг шинэчлэн мөрдүүлж хэрэглэгчдэд чанартай, шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх	Хэрэглэгчдэд үйлчлэх дэг жаягийн одоогийн хэрэгжилтийг үнэлж, үйлчилгээний шинэ хэлбэр, ухаалаг системүүдийн нэвтрэлттэй уялдуулан хийх өөрчлөлтийг тодорхойлох	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	- Хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, - Захиргаа хүний нөөцийн хэлтэс - Санхүү эдийн засгийн хэлтэс
	Мэдээллийн технологийн шинэчлэл, автоматжуулалтын нөлөөг тооцож хангах үйлчилгээний дэг жаягийг шинэчлэн боловсруулах	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	
	Хэрэглэгчийн мэдээллийг бүртгэх стандартыг тодорхойлж нэгдсэн бааз, цогц системд хөрвүүлэх бэлтгэлийг хангах	Тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын зардлын санхүүжилт	
Зорилт 2: Ухаалаг технологид суурилсан үйлчилгээний хүртээмжийг сайжруулж эрчим хүч хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх	Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдийн үйлчилгээний хамрах хүрээний зохион байгуулалтыг өөрчилж ачааллыг тэнцвэржүүлэх	Тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын зардлын санхүүжилт	- Хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, - Захиргаа хүний нөөцийн хэлтэс - Санхүү эдийн засгийн хэлтэс - Худалдан авах ажиллагаа, хангамжийн хэлтэс
	Эрчим хүчний хэмнэлт, ухаалаг сүлжээний хэрэглэгч байх, мэдээллийн технологид суурилсан үйлчилгээний боломжийн талаар мэдээлэх, сурталчлах	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	
	Хэрэглэгчдэд зайнаас үйлчлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж дэг жаягт тусгах	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	
Зорилт 3: Мэдээллийн технологид суурилсан үйлчилгээний шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлэх	Хэрэглэгч эрчим хүчний хэрэглээгээ хянах, ачаалал тооцох аппликэйшн, модуль хөгжүүлэх	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	- Хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, - Захиргаа хүний нөөцийн хэлтэс - Санхүү эдийн засгийн хэлтэс - Худалдан авах ажиллагаа, хангамжийн хэлтэс
	Тоолуурын заалт, хэрэглээний захиалгаа өөрчлөх зэргийг хэрэглэгч мэдээлэх, мэдээллийг холбогдох программд хүлээн авах технологийг бүрэн нэвтрүүлэх	Тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын зардлын санхүүжилт	

Технологийн шинэчлэлийн бодлогын зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилго: Хэрэглэгчийн үйлчилгээ, дотоод үйл ажиллагааг цогц менежментийн системд нэгтгэн удирдах замаар үр ашигтай, найдвартай сүлжээг бүтээж компанийн үнэ цэнийг нэмэгдүүлнэ.

Шалгуур үзүүлэлт: Үйл ажиллагааны зардлын бууралт ба аюулгүй ажиллагааны үзүүлэлтүүд.

Зорилт	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	Санхүүжүүлэх эх үүсвэр	Хариуцах нэгж
Зорилт 1: Өгөгдөл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.	Компанид ашиглагдаж байгаа мэдээллийн дэд сангуудыг шинжлэн их өгөгдлийн нэгдсэн сан үүсгэх архитектурыг төлөвлөх	Тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын зардлын санхүүжилт	- Ерөнхий инженер - Түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, - Хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, - Мэдээлэл, технологийн алба - Захиргаа хүний нөөцийн хэлтэс - Санхүү эдийн засгийн хэлтэс
	Түгээх сүлжээнд их өгөгдлийн нэгдсэн сан буюу “Big data” үүсгэх мэдээллийн технологийн шийдлийг тодорхойлж бизнес загвар боловсруулах, санг үүсгэх		
	Улсын бүртгэлийн алба, хот, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох бодлогын болон технологийн боломжийг бий болгож холбох /хэрэглэгчийн мэдээлэл, хаягийн мэдээлэл гэх мэт/		
Зорилт 2: Ухаалаг сүлжээний дэд системүүдийг холбож, мэдээллийн технологид суурилсан сүлжээний удирдлагыг бүрэн нэвтрүүлнэ.	Автоматжуулалтын дэд системүүдэд холбогдох шугам, тоноглолыг тодорхойлж нэмж холбох	Тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын зардлын санхүүжилт	- Ерөнхий инженер - Түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, - Хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, - Мэдээлэл, технологийн алба - Захиргаа хүний нөөцийн хэлтэс - Санхүү эдийн засгийн хэлтэс
	Бизнес загварт үндэслэн нэгдсэн мэдээллийн санд компанид ашиглаж байгаа дэд систем, программ хангамжуудыг холбох		
	Санхүү, төлөвлөлт, хангамж, түгээх, хангах үйл ажиллагааг холбох программ хангамж нэвтрүүлэх		
	Мэдээллийн өгөгдлийн нэгдсэн санг ашиглан тооцоо судалгаа хийх, шийдвэр гаргах цогц систем /хиймэл оюун ухаан/-ийг бий болгох, ашиглах		
Зорилт 3: Хөрөнгийн менежментийн цогц систем	Түгээх сүлжээнд ашиглагдаж байгаа шугам тоноглолын өгөгдлийн бүртгэлийн одоогийн дэд системүүдэд шинжилгээ хийж хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн бааз	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	- Хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс,

	үүсгэх технологийн шийдлийг тодорхойлох		- Захиргаа хүний нөөцийн хэлтэс
	Хөрөнгийн менежментийн цогц системийг нэвтрүүлэх, өгөгдлийн баазыг бүрдүүлэх	Тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын зардлын санхүүжилт	- Санхүү эдийн засгийн хэлтэс
	Санхүү бүртгэл, төлөвлөлтийн системд хөрөнгийн менежментийн системийн модулийг холбож хөрөнгийн нягтлан бодох бүртгэл, үр ашгийн тооцоог хийдэг болох		- Худалдан авах ажиллагаа, хангамжийн хэлтэс
	Түгээх сүлжээний хөрөнгийн хөдөлгөөн, үр ашгийн тооцоо, сүлжээний нэгдсэн төлөвлөлтөд үндэслэн хөрөнгө оруулалтыг төлөвлөдөг аргачлалд шилжих	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	

Хүний нөөцийн бодлогын зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилго: ур чадвартай, бүтээмжтэй хүний нөөцийг тогтвортой бүрдүүлэхэд оршино.

Шалгуур үзүүлэлт: Шилжилт хөдөлгөөний хувь, ажилтнуудын бүтээмжийн дундаж өсөлтөөр хэмжигдэнэ.

Зорилт	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	Санхүүжүүлэх эх үүсвэр	Хариуцах нэгж
Зорилт 1: Түгээх, хангах үйл ажиллагааны шинэчлэлийн зорилтод нийцүүлэн тасралтгүй хөгжүүлэн хүний нөөцийг чадавхжуулна.	Сургалтын төв ажиллуулах тусгай зөвшөөрөл авна.	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	- Хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс
	Сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх, сайжруулах, өргөжүүлнэ.	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	
	Хүний нөөцийн мэдээллийн “Хүний нөөцийн удирдлагын программ хангамж”-ийн үзүүлэлтүүдийг хөгжүүлэх, ажлын гүйцэтгэлийн мэдээллийг боловсруулах ажлын даалгаврыг боловсруулна.	Тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын зардлын санхүүжилт	
	Түгээх болон хангах үйл ажиллагааны бүхий л ажлын болон ахуйн байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангасан орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, хөдөлмөрийн аюулгүй байдлын зөв хандлага, зөв дадлыг төлөвшүүлнэ.	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	
	Ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлэх, хэрэглэгчийн байршилд суурилуулахтай холбоотойгоор хангах болон түгээх нэгжүүдэд сулран гарах ажлын байрны судалгааг хийж, чөлөөлөгдсөн ажилтнуудыг шинэ ажлын байранд бэлтгэх, сургах ажлыг байнга зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	
Зорилт 2: : Гүйцэтгэлд суурилсан цалин хөлс, урамшууллын системийг нэвтрүүлэх замаар хүний нөөцийг оновчтой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.	Гүйцэтгэлийн үнэлгээ болон нэмэгдэл ба урамшуулалт цалин нь ажилтны ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд идэвхжүүлэх хөшүүрэг болж чадаж байгаа эсэхэд шинжилгээ хийж, дүгнэлт гаргуулж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран сайжруулалт, шинэчлэлтийг хийнэ.	Тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын зардлын санхүүжилт	- Захиргаа хүний нөөцийн хэлтэс
Зорилт 3: Хүний нөөцийн удирдлагын чиг үүргийн хэрэгжилтийг	Хүний нөөцийн хөтөлбөрийг чиглэл тус бүрээр хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	- Захиргаа хүний нөөцийн хэлтэс

	Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийг үнэлж, дараагийн шатанд хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тодорхойлно.	Үйл ажиллагааны зардлын санхүүжилт	
--	---	--	--